



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/86

Шивээговь сум

Орон нутгийн хүүхэд, залуучуудад хувь хүний ур чадвар, энтрепренершипийн боловсрол олгох төслийн сумын зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Төслийг хамтран хэрэгжүүлэх тухай Хүүхдийг ивээх сангийн суурин төлөөлөгч болон аймгийн Засаг дарга нарын 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан "Харилцан ойлголцлын санамж бичиг"-ийн 2.8 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын хүүхэд залуучуудад хувь хүний ур чадвар, энтрепренершипийн боловсрол олгох төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах сумын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

Сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга:

Ерөнхий боловсролын сургуулийн захирал

Гишүүд:

Ерөнхий боловсролын сургуулийн Нийгмийн ажилтан

Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сургалтын менежер

Сумын Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Хөдөө аж ахуйн тасгийн Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо хариуцсан

421276246

мэргэжилтэн

Насан туршийн боловсрол

хариуцсан гишүүн

Бизнес эрхлэгчдийн төлөөлөл


Эцэг эхийн төлөөлөл

Сайн дурын идэвхтний төлөөлөл

Өсвөр үе, залуучуудын төлөөлөл

2. Төслийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, үр дүнг тооцож хяналт тавьж, сар тутамд тайлагнаж ажиллахыг зөвлөлийн дарга гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ